

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дамбаренчингийн Баатар	Дугаар	L238
Оршин суугаа аймаг	Өмнөговь	Оршин суугаа сум	Булган сум
Төрсөн газар	Булган сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Бумбатын хийд, Бэлчирийн хурал, Хөөврийн хурал, Байшинтын хийд, Гүж ламын хийд	Сүм хийдийн дугаар	ӨГБУ 005, ӨГБД 015
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 5-р сарын 29	Ярилцлага авсан хүн	Гантулга



Өмнөговь аймгийн Булган сумын Бумбатын хийд, Баяндалай сумын Гүж ламын хийд, Байшинтын хийд
Гантулга: За Баатар гуай та одоо өөрийнхөө энэ сүм орон нутагт байдаг үүх түүхтэй сүм хийдүүдийн туурь тэрүүний талаар товч мэдээлэл өгөхгүй юу?

Баатар: За баярлалаа. За би энэ Булган сүм бол эхнээсээ олон газраас одоо нэгдэж тавин хоёр онд сүм байгуулагдсан. Урьд нь бол их сайхан нутаг байсан. Энд бол хурал хийд гэж юм байгаагүй юм билээ. За яахав чухам хэдий үед байсныг нь мэдэхгүй ээ. Энэ Булган сумаас баруун урагшаа нэг гуч орчим км Бумбат Эрдэнэ толгой гэдэг газар нэг хурлын туурь байдаг юм. Тэр хөх зөнг нь авчраад бас суманд хэрэглэж байсан. Гурав дөрвөн суварга, дуганы тийм юу байсан.

Гантулга: Эргэн тойрон одоо байгалийнх нь байрлалыг уул усаар нь нэрлэвэл?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Баатар: За уул усаар нь хэлвэл энэ Баруун сайхан гэдэг уулын ар, тэр Бумбат эрдэнэ толгойгийн хэдэн сайхан ухаа гүвээ, элбэг сайхан устай тэр хошууны хойд хөмөрт байсан , энэ хийд.

Гантулга: Одоо бол энэний?

Баатар: Одоо бол энэний тийм түүриуд л байгаа.

Гантулга: өөр үлдсэн юм?

Баатар: Өөр үлдсэн юм байхгүй ээ.Энэ тодохой эзэн ,тийм хүн, тийм лам хувраг байсан гэсэн юм бол байхгүй.

Гантулга: Хэдэн онд...?

Баатар: Би түүриас нь л юм олж байсан.

Гантулга: Тэр улсын тийм нэртэй хийд гэж?

Баатар: Тийм нэртэй хийд гэж байхгүй. Бумбатын хийдийн түүр л гэж ярьдаг юм. За мөн Булганаасаа баруун урагшаа хорин долоо найман км-т Цагаан дашины хурал гэж бий.Тэгээд бас л нэг түүр байдаг юм.Чухам хэдий үеийн хурал. Харин сүүлхэн байсан хурал юм шиг ярьдаг юм, Цагаан дашины хурал гэж. Гагцхүү ямар лам хувраг, ямар ёс жаягтай байсан юм мэдэхгүй ээ.Тэрийг мэдэх хүн байхгүй ээ.

Гантулга: Сумын төвөөсөө одоо км-ээр яривал саяны хоёр чинь хаашаагаа зүгт хэдэн км байна?

Баатар: Аа нэг нь баруун урагшаагаа гуч орчим км. Нэг нь баруун хойшоогоо уулаадаа, тэр Гурван сайхны , Баруун сайхны ард Цагаан дэрс гэж байгаа. Энэ Цагаан дэрсний яг тэр хошууны их шүтээн Шавруун ламын овоо гэж тахидаг, тэр Ламын овоо гэж ийм сайхан хайрхан байгаа.Тэгээд тэрнийг жил болгондоо тахидаг аа.Энэ нутгийн их дээдэс Шавруун ламтан тахидаг байсан юм байна лээ.Аа тэрний ловон лам Шавруун лам гэдэг лам сангийн нь тавьдаг байсан гэж, тэр уулын ёс жаяг...

Гантулга: Шавруун лам гэдэг нь аль хурал хийдийн хүн байсан юм бол ?

Баатар: Шавруун лам ерөөсөө энэ, одоо Шавилаа л гэж яриад байдаг юм.Энэ уулынхаа өвөрт нэг хийд байдаг юм аа.

Гантулга: Шавилаа?

Баатар: Тийм, Шавилаагийн хийд л гэж яриад байдаг юм.Юуны хийд гэлээ дээ.

Гантулга: Тэр ловон лам гэж байсан?

Баатар: Тэндээ байсан хүн юм гэнэ лээ.За мөн энэ юун дээр , энэ одоо нэлээд цуутай Балчирын хийдийн маарамба , хошуу маарамба гэж хүн байсан юм гэнэ лээ. Тийм, энэ хүн бол ер нь айхтар мундаг, сайн маарамба байсан гэж ярьдаг юм, энэ маарамбын талаар.

Гантулга: Энэ улсуудын талаар түүх, домгийг нь бид нар ярилцлагынхаа төгсгөлд дэлгэрүүлж асууя.Бас өөр одоо энэ сүм хийдийн түүр гэж нэг газар хэлж байсан?

Баатар: За энэ Булганаас зүүн урд зүг рүү жар орчим км Хөвөрийн түүр гэж бий. Тэнд бас нэг хоёр гурван дуган байсан тийм суурь, түүр байдаг юм.

Гантулга: Тэрний одоо эргэн тойрон байгалийнх нь тогтоц? Газар усных нь нэрийг хэлвэл?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Баатар: За ер нь байгалийн тогтоц гэвэл сайхан гол тийштэй.Эхэн хөвөр, адаг хөвөр, дунд хөвөр гэж ийм гурван хөврийн дунд хөвөр дээр нь байгуулагдсан тийм түүрх байдаг юм аа.

Гантулга:Тэрнийг бол ерөөсөө тэгээд хэн байгуулсан энэ тэр нь бол тодорхойгүй?

Баатар: Аа тийм юм байгаагүй.

Гантулга:Тэгэхээр бол одоо энэ сүм хийдийн ямар үрсгал чиглэлийн, хичнээн дуган суваргатай байсан, юугаар барьсан байсан энэ тэр гээд энэ талаар бол мэдээлэл өгөх юм байхгүй?

Баатар: Өгөх юм тэр бол боломжгүй ээ.

Гантулга: Хэдэн ламтай ...?

Баатар: Энийг тэр айхтар олон бөө нар барьсан гэж ярьдаг юм.Далай хүзүү бөө, одоо Төмөр хэнгэрэг бөө энэ тэр гээд тийм бөөнүүд барьсан гэж ярьдаг юм аа.

Гантулга: Тэд нарын талаар үүх түүх домгийг нь та дараа дэлгэрэнгүй ярьж өгөөрэй.

Баатар: За.

Гантулга: Тэгвэл одоо энэ сүм хийдүүдийн талаар жас мас, лам нарынх нь талаар юу ч мэдээлэл байдаггүй юм байна, тийм ээ?

Баатар: Тийм.

Гантулга: Энэ нутгийн улсууд одоо шашны зан үйл эргэл мөргөл хийж одоо ном мом уншуулах болвол хаашаа явж яадаг байсан юм, ер нь? Энд хурал хийд байхгүй болохоороо ер нь энэ ойрхон залгаа хийдүүд рүүгээ явдаг байсан байх даа?

Баатар: Ер нь голцуу ер нь тэр далаад оны хаалттай байх үед амьдарч байсан болохоор тэгээд. Сүүлийн үед яахав ерээд оноос хойш тэгээд үндсэндээ энэ аймгийнхаа хийд рүү л явна.

Гантулга: Таныг бага байх үед бол өмнө одоо энэ хурал хийд байгаагүй юм чинь энэ ойролцоо том том хурал хийд рүү тэгж явж байсан гэж, улсуудын ярьж байсан яриа бол санах юм байна уу, танд?

Баатар: За ер нь яахав дээ, тэгээд надыг бага байхад сайхан хүмүүс байсан л даа. Дамбий гэлэн гэж байсан. За одоо энэ нэлээн сүүлхэн байсан, тэр Дамдин гэлэн гэж байсан.За энэ баруунаар Жамцан гэж байсан.За энд болвол би энэ номон дээр энэ нутгийн хуваргуудын товч намтарыг нэлээн бичсэн юм аа.Одоо хаанахын хийдийн ямар хүн байж болох. За энэ Агваансамба гэж энэ Байшинтын хийдийн лам байсан юм гэнэ лээ,Агваансамба гэж.Мяндаг тушаалтай хүн, за тэрүүн шиг тийм гэлэн хүн байсан байна лээ. Дамбий, Дамдин за Ишдорж гэж энэ бас Хошуу хийдийн лам байсан юм билээ.

Гантулга:Тэрбиш гэдэг нь аль хийдийн лам байсан гэнэ ээ?

Баатар:Тэрбиш нь энэ Баяндалайн тэр, ямар юмны хийд гэдэг билээ.Тэр үрд талын хийдийн хүн.

Гантулга: Өмнөговийн Баяндалай?

Баатар: Тийм, Өмнөговийн Баяндалай.Ишдорж нь бол одоо энэ Хошуу хийдийн хүн юм билээ.Гэлэн гэцэл мяндаг тушаалтай.За тэр Хошуу хийдийн ах дүү Гүүшийн Банзрагч, Лувсан гэж хоёр хүн байсан юм байна.За Ханын цагаан суваргын үнзад лам Цэрэндорж гэж байсан юм байна.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Тэр Лувсан, Банзрагч нарыг юу гэж авгайлдаг байсан гэлээ?

Баатар: Бор цагаан бандрай гэдэг байсан юм.

Гантулга: Аан зан Өөр одоо бас ямар хүмүүс байна?

Баатар: За тэгээд энд Гандантэгчилэн хийдийн гавж Гэндэндаржаа гэдэг хүн зуун есөн настай гэсэн байна лээ.

Гантулга: Аль сумын хүн бэ?

Баатар: Энэ Баяндалай сумын хүн юм аа.Гэхдээ манай суманд харъяалагдаж байсан юм, сүүлийн үед.За иймэрхүү л хүмүүс байсан даа.За тэр Баяндалайн тэр...За тэр их, Дүнгэнээгийн хурал л гээд байдаг юм, юу ч гэсэн билээ дээ. Баяндалайн яг уулын өвөрт нэг хурал байдаг юм.

Гантулга: Энэ Баяндалайгийн хийдийн энэ сүм, энэ Шавруун ламтны ?

Баатар: Шавруун ламтан бол ловон хүн байгаа юм.Гочоо маарамба гэж бас нэг Ламын хүрээнд байгаа юм .

Гантулга: Уул жаргалантын хийд, Ёст бэйсийн хүрээ, Гүж ламын хүрээ гээд л байсан гэж байгаа?

Баатар: Гүж ламын хүрээний хамба нь тэр Жамбаа маарамба , Жамбаа цорж гэж хүн байсан юм.

Гантулга: Жадавравжаа ламын хийд, Очирдарь ламын хийд?

Баатар: Тэр Жамбаа маарамба чинь ер нь төр шашин хоёроо төлөөлөнө гэсэн. Манай энэ хэдэд ярьсан байгаа юм.Чүлтэм бэйсийн отчоор Улиастайд байсан гэж.

Гантулга: Цагаан дэрсийн хийд, Хоолтын хурал гээд?

Баатар: Тийм.

Гантулга: Хуучнаар ярих юм бол та одоо нутгийнхаа хуучин засаг захиргааны байдлыг одоо Түшээт хан аймгийн аль хошуу ч гэдэг юм уу, тэр талаараа яривал?

Баатар: За ер нь Сайн ноён хан аймгийн Ёст бэйсийн хошууны хүн, би бол өөрөө.Би Балдан засгийн хошууны хүн юм аа.За энэ сумын хувьтд бол Түшээ гүн, Балдан засгийн хошуу хоёр бол хуваагаад эзэлдэг.

Гантулга: Эргэн тойрон одоо ямар ямар засгуудтай, засаг хошуутай хил залгаж байгаа вэ, энэ нутаг?

Баатар: За энэ нутаг бол ерөөсөө Балдан засгийн хошуу, Түшээ гүний хошуу хоёрын зааг.

Гантулга: Энэ хоёрын зааг?

Баатар: Энэ хоёрын зааг.

Гантулга: Хойшоо урагшаа бол тийм сум, хошуу...?

Баатар: Аа тийм юм байхгүй.Ерөөсөө энэ хоёрыг холиод л тэгээд зааг дээр нь ...

Гантулга: Энэ чинь одоо тэгээд Түшээт хан аймагтаа орчихож байна уу, тийм ээ?

Баатар: Тэгэхээр хуваагдчихаж байгаа юм.Ер нь Түшээ гүндээ орно доо.

Гантулга: Та одоо энэ сүм хийдийн хуучин одоо таны үед байсан том хутагт хувилгаан, лам хуварга том мяндагтай лам нарын талаар ярилаа ш дээ?

Баатар: Тийм.

Гантулга:Таны багш ч гээд улсууд байсан гээд?

Баатар: Тийм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Энэ улсуудынх нь талаар түүх домгийг нь сонссон, өөрөө бас мэдэрч үзсэн гэдэг юм уу, тийм юмаа яриач? Ярьж өгөхгүй юу?

Баатар: за яахав, миний одоо дуулснаар энэ нутаг хошууны тэр Шавруун ловон гэж байсан юм байна лээ, ловонтон гэж. Энэ их дөвчүү хүн байсан гэж ярьдаг. Энэ ламтны овоог тахидаг. Ламтны овоог тахих гээд ламтан овоон дээрээ очсон чинь тахилын лам ирдэггүй. Ламтан яая даа гээд л байж байтал, өө тэр шаргал дээлтэй бор халиун морьтой лам, ламтны бөх Уграй Гэндэнбал гэж мундаг том хүн байсан юм.

Гантулга: Хэн гэнэ ээ?

Баатар: Уграй Гэндэнбал, тавраан хар гэж одоо бие нь их сайхан. Тэгээд Шавруун ламтны бараа бологч. Тэр Уграй Гэндэнбал гэж мундаг том залуу бөх байж. Тэгээд л байж байсан чинь ламтан жаахан цухалдангуй яриад л ловон лам нь хаачив аа гэсэн, өө ирж байна ирж байна. Шинэхэн хүн байх шиг байна, халиун морин дээр хормой нь хойшоо мориныхоо сүүл рүү яачихсан. Овооны араас шууд л , архи уучихсан. Малгай нь шилэн дээрээ яачихсан. Заавал би нэг хэдэн юм хэлүүлж байж шээс алдах гээд байдаг гээд хачин хачин юм хэлээд унасан. Яадаг билээ, одоо ловонтон... Тэгээд л одоо сангаа тавьчихаад л , энэ хадад гэдэг дээр хурын дуудлага хийгээд л . Тэгээд л Шавруун ламтан нөгөө бараа бологчоо чи ямар морь барьсан бэ, би сахал хээрийг барьсан гээд л . Үгүй чи арай нэг хөнгөн хөлтэйг барихгүй гээд л . Тэгээд л хоёулаа энэ хадад дээр ирж хурын дуудлага хийчихээд л эргэсэн. Эргээд л нэг таван км яваад л яваагүй. Бороо цуггачихна. Тэгээд нөгөө морь нь ийм арилжаа гэнэ дээ, тэгээд халиун морь нь арилжаад байдаг. Ер нь тэр хүн дээр бороо дусдаггүй. Чи наашаа зэрэгцээд яв гэдэг, нөгөө сахал хээр нь цогиод байдаг, ерөөсөө явдаггүй, тэгж байж билээ гээд л нөгөө хүн ярьдаг.

Гантулга: Хэн гэдэг хүн?

Баатар: Гэндэнбал гэдэг хүн.

Гантулга: Тэр саяны тахидаг ламын овоо чинь эндээс хаахна байдаг овоо бэ?

Баатар: Эндээс ийшээ нэг хорин долоо, найман км.

Гантулга: Зүгээрээ яривал энэ чинь, баруун...?

Баатар: Чанх өмнө зүгт.

Гантулга: Баруун өмнө зүгт үү?

Баатар: Аа тийм.

Гантулга: Өөр?

Баатар: Гочоо маарамба Төвдөд сурж байгаад маарамбын зэрэг хамгаалчихаж гэнэ ээ. Шавруун ламтан Хаалган гэдэг хойд, их том ухаа дээр бараа бологчтойгоо хоёуулаа сууж байсныг, тэр Бялзан гэж ярьдаг юм. Бялзаны тэр хавиар сууж байгаад өврөөсөө нэг ембүү, хадаг хоёр гаргаад чи Гочоо дээр очоод ир. Хоёулаа их үерхдэг юм гэнэ л дээ. Манай ламтны бие чилээрхээд байна гээд чи очоод эм залаад ир. Тэгээд хүрээд очсон чинь аан за за, мориныхоо цулбуурыг энэ бүрүү үүдээр оруулаад ир. Ороод ирсэн морины цулбуурыг нь барьж байгаад ламтан одоо дуулна эгж баймааргүй юм даа. Жигүүр дээр суучихсан санагдаад байх юм. За хүү минь ембүүгээ

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

аваад буц аа, хадгаа залчих.Тэгж буцаж дахиж ирээд, за чи миний их хүндтэй юманд унадаг жороо халиун морь байдаг.Чи миний халиун морийг аваад яв.За тэгээд л морийг нь бариад л, тэгээд маргааш нь их гоёж бариад л очсон. Тэгээд гурван гэр байсан.Дунд гэрт нь гурав хоноод л тэр хоёр гэрээ шалгаад л, тэр үхэр адуу, шарга адуу байдаг байсан гээд л тэр бараа бологч л ярьдаг байсан. Тэгээд тэр их сайн маарамба байсан.Тэрний хүү нь Жанцан маарамба гэж сая болтол байсан.Тэр ургамалд их сайн, ургамлаар эмчилдэг.Би бас тэр хүн дээр ургамал заалгаад л их яаж байсан.Одоо тэр хүний хэлснээр найман төрлийн эм нийлүүлээд, бас өөр өвчтэй хүнд...

Гантулга: Тэгээд олон түмэнд туслаад?

Баатар: Тэрийг бас их сонирхдог байсан юм.Тэгээд л Жанцан багш ч ер нь сайн хүн байсан даа, тэгээд л.

Гантулга: Хэдэн оны хүн юм?

Баатар: Жанцан багш ч сая бүр далаад онд байсан л даа.

Гантулга:Тэр Гочоо маарамба чинь аль хийдийн хүн гэж байлаа?

Баатар: Энэ тэр ямар...Эхэн заг биш ээ, юуны хийд гэж байлаа даа.

Гантулга: Аль суманд?

Баатар: Энэ Баяндалайд харъяалагдана л даа.За тийм хүн байсан.за тэр хүний одоо Жанцан гэлэнгийн нэг хүү нь одоо Цоож гэж нэлээн юмтай хүн байсан юм. Нэлээн юм ярьчихна.

Гантулга: Цоож оо?

Баатар: Тийм.

Гантулга: Өмнөговь аймаг дээр?

Баатар: Тийм, Өмнөговь аймаг дээр.

Гантулга: Энэ Цоож гэдэг хүн, аа энэ Сэврэйгийн?

Баатар: Тийм. Тэр хүн бол наад хүний талаар нэлээн юм мэдэх хүн.Ном судар их судалдаг. Ер нь айхтар судалгаатай хүн бий шүү.

Гантулга: Өөр одоо түрүүн дурдаж байсан улсуудын домог түүхээс яривал?

Баатар: За яахав, одоо Байшинтын хийдийн одоо Буурал гэгээн гэж өргөмжлөгдсөн гэгээн байдаг юм. Өмнө газраас яг тодорч байсан.За Буурал гэгээн бас л их ид шидтэй, сайн өндөр насалсан, зовхи нь буучихаад л шүдэнзний модоор нүдээ яахчихдаг. За энэ хүний тухай ер нь Байшинтын хийдийн лам нар гэгээнтнүүдийн тухай хүмүүсийн ярьж байсныг сонсоход энэ Буурал гэгээнтэнд Манлай сумын харъяат нэг хүн хоёр нүд нь хараагүй болчихоод тэгээд дүүгээ авч өмнө газар явж хойд насаа даатгана гээд дөрвөн морьтой манлай бөх дүйрэг хонгорын зоо гэдгээс гарч...

Гантулга: Ямар хонгорын зоо гэнэ ээ?

Баатар: Дүгрэг хонгорын зоо гэдгээс гарч урагшаагаа яваад энэ Баяндалайн урд Бардан чандманий хоолойд явж очтол олон морьтой бараа бологчид дээдэс үаларч явна аа, бидний урдаас ирж явна гэхэд тэр ах нь за одоо яг ирж яваа бол морьноосоо буу, хормойгоо тосоод сайхан залбираад бай гээд тэгээд сууж байтал олон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

морьтой улсууд давхиад ирсэн.Тэгээд юун улсууд юу болж байгаа ю мгэтэл харин одоо мэлмийгүй болчоод өмнө газар хойд насаа даатгаж буян үйлдэж явна аа гэсэн.Тэгээд алив хүрээд ир гэсэн.За чи энэ дөрвөн морийг миний цаана нийлүүл.Аа чи наад ахыгаа аваад буц.Гэрийн баруун урд талд их хөөрхөн ухаа хонгор толгой бий.Тэрэн дээр гараад чи нүдээ нээ, хар гэж хэлээрэй гэсэн.Тэгээд энэ хоёр одоо морио тэнд хураалгачихаад за тэр үеийн улсууд одоо даруу сайхан болохоор ямар гэгээн дээдэс заларч явна аа, аа Бүүрал гэгээнтэн. Одоо бол их заргалдах байх л даа, дээрэмчин гэж. Тэгээд морио хураалгачихаад нөгөө хоёр одоо яадаг билээ, за ойр зуурын юмаа авчихаад л буцаж явж, тэгээд л явсаар хөдөө хоноод л өглөө яг арван цагийн үед баруун урд толгой дээр нь гараад ирсэн.Бэргэн эгч нь ямаагаа, намрын ямаа саагаад л сууж байсан, хүүхэд нохой...Хүүе ах аа хараа, танайх тэр байна, тэгээд л харсан чинь нүд нь мэлс хийгээд ороод ирсэн.Тэгээд одоо энэ гэгээнтний талаар ийм яриа байдаг , өшөө ч яриа байдаг.Тэрний дараа тодорсон Дашням гэгээн гэдэг хүн , за гучин есөн онд цэрэгт татагдаад Тамсаг ууланд цэргийн алба хааж яваад бүүгаа арчдаггүй , тэгээд анги дотор л нэлээн яриа болоод штабаас зориуд ирж тэгээд зориуд бүүгаа арч гээд шаарлага тавьсан чинь өө одоо би таныг харж байхад арчаадахая гээд бууныхаа төмрийг мушгиж эргүүлээд арчихаад тэгээд эргүүлээд угсарчихсан.Тэгээд одоо ийм боллоо гээд маршал Чойбалсанд илтгэчихсэн чинь, Балдан засгийн хошуунаас ирсэн цэрэг гэсэн чинь тэгвэл нутагт нь буцаагаад явуулчихая гэж.Тэгээд энд сүүлд байгаад л байдаг юм, хоёр морьтой давхиад л байдаг байсан гэнэ лээ.Тэгээд сүүлд нь тэр хүн таалал болоод тэгээд хойд дүр нь Жасрай гэгээний дүр тодорсон юм гэнэ лээ.Тэгээд Өвөрмонголд төрсөн. Жасрай гэгээнтэн одоо энэ Ар Өвөр монголыг одоо холбосон нөлөө бүхий том одооодоо амьд сэрүүн амьдарч байгаа.Тэр хүн миний багш хүн.Тэр лүн хайлж байсан багш.Одоо энэ зургаан сард ирэх байх.Тэрний хүү нь Сүхээ гэж их том маарамба юм билээ.За энэ улсын хувьд ийм л байна.

Гантулга: Тэрбиш лам гэж бас энэ дээр гарч байна?

Баатар: Тийм.

Гантулга: Тэр хүний талаар?

Баатар:Тэрбиш гуай их мундаг номтой хүн байсан. Тэрбиш гуайн хүү нь одоо энэ сүмд Мөнхөө гэж энэ лам дээр хурлын орлогч хийж байна